



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар А/М

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Засгийн газрын 2022 оны 52 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2022 оны 268 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” аж ахуйн тооцоотой төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Наран-Идэрийн ажлыг хүлээлцүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:

В.Дарханбаатар

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын

Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн Удирдлага, төлөөллийн албаны дарга

Гишүүд:

Г.Нямдаваа

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн

А.Өнөрцэцэг

Биеийн тамир, спортын улсын хорооны Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн Төсвийн төвлөрүүлэн захирагчийн төсвийн ерөнхий нягтлан бодогч /зөвшилцсөнөөр/

Б.Наран-Идэр

“Үндэсний шигшээ багийн бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал

О.Баярбат

“Спортын бэлтгэл, сургалтын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал /хуучин нэрээр/

Нарийн бичиг:

Д.Сонинбилэг

“Техник спортын төв” төрийн өмчит үйлдвэрийн газрын зохион байгуулагч /хуучин нэрээр/

2. Б.Наран-Идэрийн ажлыг зохих журмын дагуу 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор хүлээлцүүлж, дүнг танилцуулахыг ажлын хэсэг (В.Дарханбаатар)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

132003202

ТӨБЗГ тушаал-/2022